



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/116

Улаанбаатар хот

Ариутгаж, халдваргүйжүүлсэн эмнэлгийн хог хаягдлыг дарж, булшлах талбайн байршлыг тогтоох тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, 2016 оны "Газар эзэмшүүлэх тухай" А/384 дүгээр захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалт, "Элемент" ХХК-ний 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 19/90 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт ариутгаж, халдваргүйжүүлсэн эмнэлгийн хог хаягдлыг дарж булшлах талбайн байршлыг хавсралт ёсоор баталсугай.


2. Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгт ариутгаж, халдваргүйжүүлсэн эмнэлгийн хог хаягдлыг дарж булшлах үйл ажиллагааг эрхэлдэг "Элемент" ХХК нь нийслэлийн хэмжээнд эмнэлгийн хог хаягдлыг төвлөрүүлэн хүлээн авах нэг байгууламжтай байх нь байгалийн болон гэнэтийн давагдашгүй хүчин зүйл тохиолдох үед хөл хорио тогтоож, эмнэлгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйл ажиллагаа саатах, эмнэлгийн хог хаягдлыг хотын зүүн захаас баруун захад нэг байршилд төвлөрүүлэн тээвэрлэхэд хог хаягдлын үйлчилгээний зардал, төлбөрийн хэмжээ нэмэгдэх эрсдэл үүсч болзошгүй гэж үзэн Налайх дүүрэгт хотын зүүн бүсийн эмнэлгийн хог хаягдлыг хүлээн авч саармагжуулах нэмэлт салбар байгуулж, компаний нэршилд өөрчлөлт оруулан хотын баруун бүсийн эмнэлгийн хог хаягдлыг "Элемент медикал" ХХК хариуцахаар зохион байгуулалтын өөрчлөлт хийсэнтэй холбогдуулан Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгийн тогтоосон байршилд ариутгаж, халдваргүйжүүлсэн эмнэлгийн хог хаягдлыг дарж булшлах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, стандарт шаардлагын дагуу хийж гүйцэтгэхийг "Элемент медикал" ХХК /Б.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.

3. “Элемент медикал” ХХК-ний ариутгаж, халдваргүйжүүлсэн эмнэлгийн аюулгүй хог хаягдлыг дарж булшлах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хот тохижилтын газар /Б.Бямбадорж/-т даалгасугай.


4. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2013 оны А/52 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 04 сарын 24-ны өдрийн
А.М.Б. тушаалын хавсралт



НАРАНГИЙН ЭНГЭРИЙН ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГТ
АРИУТГАЖ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛСЭН ЭМНЭЛГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ДАРЖ
БУЛШЛАХ ТАЛБАЙН БАЙРШИЛ

Дугаар	Х	Ү	Өндөр	Урт	Цэгүүд
1	5314593.720	633705.713	1365.219	191.65	1-2
2	5314784.127	633727.544	1365.219	68.97	2-3
3	5314785.656	633796.496	1365.219	193.40	3-4
4	5314592.285	633793.108	1365.219	87.41	4-1